

1. Жуулчны баазын товч мэдээлэл

Нэр:	“Бүрэн” жуулчны бааз
Үйл ажиллагаа явуулж буй байршил:	Өмнөговь аймаг, Сайншанд баг, Говь гурвансайхан байгалийн цогцолборт газар
Үйл ажиллагаа хэрэгжүүлэгч:	“Дойдо” ХХКомпани Улсын бүртгэлийн дугаар: 9011233054 Регистрийн дугаар: 5373778
Компанийн хая:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, 52-16 тоот Утас: 88115701, 99188144.
Газар ашиглах зориулалт:	Аялал жуулчлал
Ашиглах талбай:	3 га

Төслийн хүчин чадал, техник технологи

Тус “Бүрэн” аялал жуулчлалын бааз нь нэг ээлждээ 60 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай, гэр буудал, зоогийн газар, рестораны зориулалт бүхий үйлчилгээний барилга, ариун цэвэр болон угаалга индүүдлэгийн байр, ажилчдын байр, оффис, сүүдрэвч, харуул хамгаалалтын байр, машины зогсоол, ногоон байгууламжууд барьж байгуулна. Жуулчны баазад нийт 15 хүн ажиллана.

Хүснэгт 01. Баазын тохижилт

№	Объект, байгууламж	Тоо, ширхэг	Тайлбар
1	Ресторан	1	6х21,5 метрийн хэмжээтэй, 60 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай рестораны байшин.
2	Гал тогоо	1	14х5,6 метрийн хэмжээтэй, жуулчид, зочдын хоол ундыг бэлтгэх гал тогоо
3	Гэр буудал	20	5 ханатай, жуулчид зочид амарч хоноглох зориулалттай, дотроо бие засах суултуур болон усанд орох дүүшээр тоноглогдсон цомцог гэр.
4	Гэр буудал	10	4 ханатай, жуулчид зочид амарч хоноглох зориулалттай, энгийн монгол гэр
5	Ариун цэврийн болон, угаалга индүүдлэгийн байр	1	10,5х5,6 метрийн хэмжээтэй байр. Эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 бие засах суултуур, душ, угаалгын тосгуур байна. Мөн баазын хөнжил, бүтээлэг, алчуур, цагаан хэрэглэл зэргийг угааж цэвэрлэн, индүүдэж бэлэн болгох ажлын өрөөтэй.
6	Гүний худгийн байр	1	Газрын гүнээс гүний ус татаж, баазын хэрэглээнд түгээх худгийн насосыг байрлуулна.
7	Ажилчдын байр, оффис	1	Баазад ажиллах ажилчдын амрах, хоноглох өрөөнүүд, баазын удирдлагын оффисын өрөө тус тус байрлана. 5,8х32,9 метрийн хэмжээтэй, 6 өрөөтэй байр.
8	Автомашин зогсоол	1	Нийт 30 хүртэл автомашины багтаамжтай гадна зогсоол.
9	Сүүдрэвч	4	10 хүн сууж, сэрүүцэж амрах модон сүүдрэвч.
10	Хүлэмж	1	15х5 метрийн хэмжээтэй, хүнсний нарийн тогоо тарьж, жуулчид зочдын хоол хүнсэнд бэлтгэх зориулалттай хүлэмж

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Төслийн байршил: Өмнөговь аймгийн Сэврэй сум нь Өмнөговь аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 740 км, аймгийн төвөөс 216 км зайд 816306.5 га газар нутгийг хамран оршино. Баруун хойт талаараа Баянхонгор аймгийн Баянлиг, Хойт талаараа Өвөрхангай аймгийн Богд, зүүн хойт талаараа өөрийн аймгийн Булган, Зүүн талаараа Баяндалай, өмнө талаараа Ноён, баруун талаараа Гурвантэс сумдтай хиллэдэг. Газрын гадаргын хувьд далайн түвшнээс дээш 1000-2600 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд гурван тойрогт хамаарна.



Зураг 01. Төслийн талбай

Хүснэгт 01. Солбицлын цэг

д/д	Нэгж талбайн хэмжээ	Цэгийн дугаар	Цэгийн солбицол	
			Х	У
1	3.0 га	1	102° 16' 00.079”	43° 48' 03.508”
		2	102° 15' 59.917”	43° 48' 07.056”
		3	102° 16' 02.580”	43° 48' 07.120”
		4	102° 16' 2.320”	43° 48' 12.819”
		5	102° 16' 2.899”	43° 48' 12.833”
		6	102° 16' 7.391”	43° 48' 09.087”
		7	102° 16' 6.380”	43° 48' 03.559”

Физик газарзүйн нөхцөл: Өмнөговь аймгийн Сэврэй сум нь Өмнөговь аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 740 км, аймгийн төвөөс 216 км зайд 816306.5 га газар нутгийг хамран оршино. Баруун хойт талаараа Баянхонгор аймгийн Баянлиг, Хойт талаараа Өвөрхангай аймгийн Богд, зүүн хойт талаараа өөрийн аймгийн Булган, Зүүн талаараа Баяндалай, өмнө талаараа Ноён, баруун талаараа Гурвантэс сумдтай хиллэдэг. Газрын гадаргын хувьд далайн түвшнээс дээш 1000-2600 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд гурван тойрогт хамаарна. Нутгийн хойт хэсэг нь Их бага Богдын уулс, дунд хэсэг нь Гурван сайхан уулсын, Өмнөд хэсэг нь Алтайн өвөр говийн тойрогт хамаарна. Геоморфологийн хувьд говь цөлийн бүсэд багтдаг. Газар хөдлөлийн идэвхтэй бүсэд оршдог. Сумын нутаг дэвсгэр нь өндөр уулс, гүвээ толгод, тэгш тал, элсэн манхан, хотгор хоолой хосолсон шинжтэй боловч ихэнх хэсгийг нь уулс эзэлнэ. Говь-Алтайн нурууны уулсын тогтолцоонд хамаарах тул гадаргын ерөнхий төрх өндрийн хэмжээ байрлалын онцлогоороо ялгаатай мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой.

Уур амьсгал: Тухайн газар орны уур амьсгал нь хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл уур амьсгалын мэдээ нь тухайн газар орны цаг агаарын ерөнхий шинж нь жилийн аль сард ямар байх вэ гэдгийг илэрхийлдэг. Уур амьсгалын мэдээлэлд агаарын температур, хур тунадасны хэмжээ чухал үүрэгтэй байдаг. Тухайн газар орны уур амьсгалын төлөв байдал ямар байх вэ гэдэгт газрын гадаргын өндөршил, газарзүйн өргөрөг, түүнд ойрхон байгаа ус бүхий гадарга, ургамал нөмрөг, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг. Цаг уурын үзүүлэлтийг олон жилийн дунджаар авч үзэхэд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж температур 50С, агаарын үнэмлэхүй их температур 7-р сард +380С, үнэмлэхүй бага температур 1-р сард -300, хур тунадасны жилийн дундаж хэмжээ 94 мм, салхи ихтэй, салхины дундаж хурд 4.1 м/сек, 15 м/сек-ээс их хурдтай хүчтэй салхи ихэвчлэн хавар намрын улиралд ажиглагдах ба жилд шуургатай өдрийн тоо 100-120 хоногт хүрнэ. Ургамал ургах бололцоотой хоногийн тоо 141 хоног байна.

Дулаан хүйтний горим: Өмнөговь аймгийн төв, баруун талын сумд Тухайлбал Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй, Хүрмэн сумдын нутгаар жилийн дундаж агаарын температур 3.9-6.1 орчим байхад зүүн өмнө талын талархаг нутгаар 7.4 хүрч Өмнөговь аймгийн бүх нутагт хамгийн хүйтэн сар 1 дүгээр сар -11,5-16.8 хамгийн дулаан нь 7 дугаар сард олон жилийн дунджаар агаарын температур 20.2-24.0 градус байдаг. Агаарын дундаж температур нь жил бүр харилцан адилгүй, олон жилийн дундаж хэвийн хэмжээнээс дулаан хүйтэн янз бүр байдаг юм. Цаг уурын станц харуулын ажиглалтын материалаас үзэхэд 1968, 1969, 1977 онуудад нэлээд хүйтэн жил байсан байна, Агаарын үнэмлэхүй их температур баруун хойт, хойт талын сумдын нутгаар 32.6-39.9, төвийн нутгаар 35-35.8 бусад нутгаар +38.6-41 хүрдэг юм. Номгон, Мандал-Овоо, Ханбогд сумдын нутгаар хаврын цочир хүйтрэлт дунджаар 5 сарын 5-наас 5 сарын 7-ны үед бусад нутгаар 5 сарын хоёрдугаар 10 хоногт ажиглагддаг байна. Намрын цочир хүйтрэлт Гурвантэс, Сэврэй, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо, Ханбогд сумдад 10 дугаар сарын 1-10 хоног бусад сумдаар 9 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт ажиглагддаг

Салхины горим: Манай оронд жилийн хүйтэн улиралд эсрэг циклон, дулаан улиралд шатлуур багатай нам даралтын орон зонхилох тул салхины хурд өтөнхийдөө бага, жилийн дундаж салхины хурд 2.6-5.5 м/с орчим байна. Сарын дундаж салхины хурд хавар хамгийн их, өвөл зун бага байдаг ерөнхий шинжтэй байдаг. Салхи ихтэй, салхины дундаж хурд 4.1 м/сек, 15 м/сек-ээс их хурдтай хүчтэй салхи ихэвчлэн хавар намрын улиралд ажиглагдах ба жилд шуургатай өдрийн тоо 100-120 хоногт хүрнэ. Ургамал ургах бололцоотой хоногийн тоо 141 хоног байна.

Агаарын чийгшил: Нэгдүгээр сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 50%-аас доош, долоодугаар сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 40%-аас доош байна. Харин гантай зуны давтагдал 35%-аас дээш газар нутгийн нийт чийгшил нь нутгийн өмнөд хэсэгт 50-100 төвийн хэсэгт 150-200 мм байдаг.

Харьцангуй чийг: Агаарын чийгийн хэмжээ усны ба газрын гадаргаас хэдий хэмжээний ус ууршилтын явцаар агаарт дэгдэн гарч байгаа хэмжээгээр тодорхойлон. Агаарын чийгийг үнэмлэхүй, харьцангуй, дутагдал гэж ялган үздэг. Харьцангуй чийг гэдэг нь тухайн агаарт чийгээр ханахад шаардагдах чийгийн хэмжээний хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм (Санжмятав.З, Монгол орны байгалийн газарзүй). Тиймээс Сэврэй сумын харьцангуй чийгийн дундаж нь 42.2% байна. Агаарын харьцангуй чийг 30%-аас бага байх өдрийн тоо 87 хоног байна.

Хур тунадас болон чийгшилийн горим: Өмнөговь аймгийн нийт нутаг хуурай уур амьсгалын бүсэд багтана. Агаар хуурай, хөрснөөс уурших чийгийн нөөц бага учраас жилийн дулааны улирлын харьцангуй чийгшилийн дундаж 29-50% өвлийн улиралд 50-73% хэтэрдэггүй байна. Олон жилийн дунджаар жилд Даланзадгад, Ноён, Гурвантэс, Ханхонгор, Булган, Манлай суманд 102.1-132.9 мм тунадас, Баян-Овоо, Номгон суманд 63.2-70.9 мм бусад сумдад 80-100 мм тунадас унадаг. Жилд унах тунадасны хэмжээ харилцан адилгүй зарим жил олон жилийн дунджийн хэмжээнд орж байхад зарим жил олон жилийн дунджийн хэмжээнээс харьцангуй их, бага янз бүр ордог. Тэр ч байтугай 1 хоногт жилд орох хур тунадасны ихэнх нь орох тохиолдол ажиглагдаж байсан. Тухайлбал: Даланзадгад 1977 онд 2,35. 3мм, Номгонд 1969 онд 156 мм тунадас жилдээ орж байсан бол Даланзадгадад 1956 оны 8 дугаар сарын 5-нд 137,8 мм тунадас 1 хоногт орж байсан байна. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр 50мм, төвийн болон хойд хэсгийн ихэнхи нутгаар 100-150мм тунадас унадаг. Хүйтэн улиралд орох хур тунадасны жилийн нийлбэр хэмжээ нь өмнөд хэсгээр 5мм-ээс доош, хойд хэсгээр 5-10мм. Харин жилдээ дунджаар 10 хоног л цас ордог. Дулаан улирлын хур тунадасны жилийн нийлбэр нь өмнөд хэсэгтээ 50-аас доош бусад хэсгээр 50-100 мм, 5 мм ба түүнээс илүү хур тунадастай өдрийн тоо жилд дунджаар 10 өдөр байдаг. Тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа XII.10-аас хойш тогтдог ба II.10-аас өмнө цасан бүрхүүл нь ханзарч эхэлдэг.

Геологийн тогтоц: Тус сумын ихэнх нутгаар цэрдийн системийн дээд болон доод нэгтгэлгээнд хамаарагддаг. Нутгийн зүүн хэсгээр чулуун нүүрсний системийн дээд нэгтгэлгээ-пермийн системийн доод нэгтгэлгээ (хуваагаагүй) оршдог. Харин нутгийн баруун хэсгээр триасын системийн дээд нэгтгэлгээ-юрийн системийн доод нэгтгэлгээ (хуваагаагүй) багтаж байна. Үүнээс харахад Алтан уул орчмоор силүрийн систем, Нэмэгт уул орчимд чулуун нүүрсний системийн доод нэгтгэлгээнд хамаарагдаж байна. Тост уул нь кембрийн өмнөх үед хамаарагдана. Мөн галт уулын бялхамал чулуулаг дах тэнгисийн холимог чулуу, хүрмэн чулуу, риолит, эх газрын чулуулаг, элсэн чулуу, гравелит, конгломерат, тунамал брекчи, түүний дотор нүүрс агуулагч чулуулаг нилээдгүй талбайг эзэлнэ. Сумын нутгийн зүүн хэсгээр Улаан ба алаг өнгөт тив гаралт чулуулгийн, саарал өнгөт элс-сайргархаг ба элс хайргархаг чулуулгийн тавцангийн хучаасны хэвшилд багтдаг. Нутгийн баруун хэсгээр Гранодиорит-боржингийн ба боржингийн, зарим хэсэгтээ хүчиллэг бялхамал чулуулагтай, тэнгисийн ба эх газрын, Боржин-лейкоборжингийн, монцонит-сиенит-граносиенитийн, боржин-граносиенитийн, Андезит-дацитын, андезит-дацит-риолитын риолитын, Зарим хэсэгтээ хар занар бүхий цахиурлаг занарын ба ногоон занарын хэвшлүүд хойноос урд чиглэлд шаталсан байдлаар тус тус тархсан байна.

Гадаргын ус: Тус жуулчны баазаас өмнө зүгт 3.2 км-ийн зайд Хонгорын гол оршино. Өмнөговь аймгийн есөн гайхамшигийн нэг, Сэврэй сумын нутагт Сэврэй сумаас хойш 20 гаруй км, аймгийн төвөөс баруун тийш 216 км зайд орших үргэлжилсэн элсэн манхан. Элсэн манханы урт нь 130 гаруй км, өндөр нь газрын гадаргаас дээш 195 м, өргөнөөрөө 3-20 км. Сэврэй, Зөөлөн, Баян бор нуруу хэмээх үргэлжилсэн их уулсын дундуур баруунаа зүүн тийш сунаж тогтсон элсэн манхан юм. **Газар**

Ургамлан нөмрөг:

Төслийн талбай болон талбайн ойр орчимд Бутлаг үетэнт ба заримдаг сөөгөнцөр-бушлаг үетэнт цөлжүү хээрийн Говь-Алтайн хэв шинжийн чулуусаг алаг өвс, агь, ерхөг, хялганат, Говийн умард-монгол хэв шинжийн харгана бүхий агь-хазаар өвс, хялганат, хаяа уулс, цав толгод, тал газар хотгорын говийн умард хэв шинжийн баглуур-хялганат, баглуур-таана-хялганат зонхилно.

Хөрс: Хөрс газарзүйн мужлалаар: Говийн мужийн, Говь-Алтайн дэд мужийн 36-р тойрогт харьяалагдана. Заримдаг цөл, цөлийн хөрсний химийн шинж нь: Сульфатат-хлорлог ба хлорт сульфаттай, заримдаа бор, ионы нөлөөгөөр илүү шүлтлэг шинжтэй байдаг давсархаг хөрс юм. Хөрсний эвдрэлд хүчтэй элэгдсэн гадарга, хийсэх аюул бүхий сайрын эвдрэлтэй хөрс зонхилно. Хуурай хээрийн ба цөлжүү хээрийн хөрс зонхилсон. Тал хотгор, жижиг цав толгод бүхий заримдаг цөлийн хөрс тархсан. Үндсэн хэв шинж нь: гөлтгөнөгүй, цөлөрхөг хээрийн бор, шалархуу элсэрхэг сайрын (гүйцэт тогтворжоогүй) бүтэцтэй.

Амьтан: Сэврэй сумын нутаг нь Төв азийн их цөлийн хамгийн хойт захын хэсэг нь хамрагдах тул говийн цөлийн харьцангуй нэг хэвийн байгальтай зэргээс хамааран амьтны аймаг нь зүйлийн бүрэлдэхүүн болон зүйлийн тоогоор цөөн ч Төв азийн уугуул унаган амьтад, эртний гарал үүсэлтэй ховор, ховордсон олон амьтан нутагшсан. Сумын нутаг дэвсгэрт дэлхийн улаан номонд бүртгэгдсэн дархан цаазтай амьтан Хулан, Ирвэс, Аргал янгир, Хар сүүлт байхаас гадна Шилүүс, Чоно, Үнэг зэрэг ан амьтад элбэг тохиолдоно. Мөн сумын нутагт ёл, хар тас, хонин тас буюу цасны хажир, нөмрөг, бүргэд зэрэг томоохон махчин шувууд, элээ, тогоруу, цөцгий, ангир, зэрлэг болон чүрх нугас, хавтгалж, тоодог, хээрийн галуу, хар галуу буюу гогой зэрэг нүүдлийн болон ус намгийн шувууд, хэрээ, турлиах, сар, бор харцага, идлэг болон начин шонхор, үнсэн дунхай зэрэг махчин шувууд хойлог% ногтруу, хахилаг, ууль, шар шувуу, хөхөө, өвөөлж, чогчиг, болжмор, хулан жороо, нэх мэт агнуурын болон жижиг шувууд байдаг..

Түүх, соёлын дурсгалт зүйлс:

Төслийн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдох аваас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шаардлагатай.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Тус төслийн бүх үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо БОАЖЯ-ны 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн а-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалд тусгагдсан нөлөөллийн үнэлгээний аргачлалыг ашиглав.

Үйл ажиллагааны явцад тоос шороо бос ч ил гарсан гадаргуугаас салхиар зөөгдсөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс, ургамлыг дарж байгалийн өнгө төрхийг түр муутгах, ургамал амьтны хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулж болзошгүй байна. Байгаль орчин болон нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 14.2% нь бага, 71.4% нь дунд зэрэг, 14.3% нь эерэг байна. Тус нөлөөллийг нэгтгэн дүгнэж үзвэл:

- Газрын гадаргад нөлөөлөх нөлөөллийн 66.6% нь **дунд**, 33.4% нь бага.
- Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн 25% нь их, 50% нь **дунд**, 25% бага,
- Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөллийн 50% нь бага. 50% нь **дунд**.

- Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн 50% нь **дунд**, 50% нь бага,
- Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь **бага**
- ТХГН-т үзүүлэх нөлөөллийн 25% нь бага, 50% нь **дунд**, 25% нь их,
- Нийгэм эдийн засагт эерэг нөлөөтэй байна

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Тус аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) болон байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.** Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь дараах зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

Агаар, ус, хөрсөн бүрхэвч, ургамал, амьтан болон тухайн орчинд ажиллаж буй хүмүүст төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох, шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжих эхний 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын тооцоог зах зээлийн өнөөгийн үнийн дүнгээр тооцов.

Төсөл хэрэгжүүлэгч БОННУ батлагдсаны дараа жилээс эхлэн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль хамгаалах хууль тогтоомж, төслийн БОННУ-ний үр дүн, батлагдсан БОМТ (энэхүү төлөвлөгөө)-нд үндэслэл болгоно.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн болон хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан зохих шийдвэрийг гаргуулж ажиллах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлнэ.

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ-/2026 он./

ТУХАЙН ЖИЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (1-жилээр) /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР					
Жуулчны бааз ашиглалтын явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд төслийн талбай орчмын шороон замаас тоосжилт үүсэх дуу чимээ, уурын зуухны утаа, хог хаягдал зэрэг болно.	Баазын үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх	Төслөөс гарч буй хатуу, шингэн бүх төрлийн хог хаягдал.	120.000	2026 он 8 сар	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Монгол Улсын агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005; - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, - Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ - MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
	Аялал жуулчлал, амралтын баазын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утааны бохирдуулагч зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зориулалтын шүүлтүүр тавих, солих	Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгсэл	100.0	2026 он 7 сар	
Нийт дүн			220.000		

ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС					
Газрын доорх усыг авч ашигласанаар газрын доорх урсацын горим алдагдах, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох. Мөн Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэх зэргээс гүний усыг бохирдуулж болзошгүй.	Бохир ус дамжуулах хоолойн холбооснуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийх	Бохир ус дамжуулах хоолой, холбоос	100.0	2026 он 6 сар	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.),
	Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг үерийн болон гадаргын усны урсацаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Төслийн талбай	200.0	2026 он 7 сар	Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал),
	Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж. эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Төсөлд ашиглагдах ус	100.0	2026 он 6 сар	Усны чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2014 Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
	Ус ашиглалтын гэрээний дагуу төлбөр тооцоог тогтмол цаг тухайд төлж барагдуулж байх	Гүний худаг	-	2026 он 10 сар	Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/
Нийт дүн			400.000		

ХӨРС БОЛОН УРГАМЛАН БҮРХЭВЧ					
Автомашины хөдөлгөөн, үйлчлүүлэгчдийн тоог хэт олшруулснаас хөрс, ургамал талхлагдах, элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй.	Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх	Төслийн талбай орчмын шороон зам	100.0	2026 он 5 сар	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ хэмжээ/
	Төслийн объектууд хооронд тавьсан автозам болон явган хүний замыг сэргээн засварлаж байх	Төслийн талбайн дотоод автозам,	200.0	2026 он 6 сар	
	Ногоон байгууламжийг байгуулахдаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, хөрсийг сайжруулан үржил шимийг нэмэгдүүлэн, ургамалжуулах	Төслийн талбайд	800.0	2026 он 9 сар	
Нийт дүн			1.100.000		
			1.720.000		

ТУХАЙН ЖИЛИЙН ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжид	100.0	2026 он 6 сар	- Гамшгаас хамгаалах тухай хууль, - “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, - Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	100.0	2026 он 8 сар	
	Үерийн хамгаалалтын нам болон өндөр даланг байгуулж, жалга, суваг шуудуу руу урсахаар засаж тохижуулах	Төслийн талбай орчим	200.0	2026 он 7 сар	
	Хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх	Төслийн талбай орчим	100.0	2026 он 7 сар	
	Үйлчлүүлэгчдэд санаандгүй гал алдахгүй талаар сурталчлах	Төслийн хүрээнд	50.0	2026 он 8 сар	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	200.0	2026 он 7 сар	
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийг бүхэлд нь	200.0	2026 он 8 сар	
Нийт дүн			950.000		

ТУХАЙН ЖИЛИЙН ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
- Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох. - Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй. Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй.	Хатуу хог хаягдлын цэгийг засварлах.	Төслийн хүрээнд	120.0	2026 он 6 сар	- Хог хаягдлын тухай хууль - Ариун цэврийн тухай хууль - MNS 6043:2013 - MNS 4943:2015 - MNS 5924:2015
	Шингэн бохирын хаягдлыг халих, шүүрэхээс найдвартай хамгаалах менежментийн үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт	Төслийн хүрээнд	200.0	2026 он 7 сар	
	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байх /сард 1-2 удаа/	Төслийн хүрээнд	720.0	2026 он 6, 7, 8 сар	
Хог хаягдлын менежментийн нийт зардал			1.040.000		

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод үйл ажиллагаа			
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль орчны аялал жуулчлалын газар болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Төслийн хүрээнд	200.0	2026 он 9 сар
Эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Ажилчид	12х25.0=300.0	2026 он 9 сар
Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Төслийн хүрээнд	100.0	2026 он 8 сар
Ажилчдыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад хамруулах	Ажилчид	2х250.0=500.0	2026 он 7 сар
Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулж байх	Төслийн хүрээнд	100.0	2026 он 9 сар
Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	300.0	2026 он 10 сар
Говь Гурвансайхан БЦГ-ын хамгаалалтын захиргаа, БОНХЯ- тай байгуулсан газар ашиглалтын гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Төслийн хүрээнд	1.800.0	2026 он 7 сар
Сэврэй сумын захиргаа, Говь Гурвансайхан БЦГ-ын захиргаа болон жуулчны баазуудтай хамтран Хонгорын голын бүс нутгийн хатуу хог хаягдлын цэгийг тогтоох. зохих журмын дагуу ашиглах	Төслийн хүрээнд	120.0	2026 он 6, 7, 8 сар
Нийт дүн	3.420.000		

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР- /2026 он./

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.	Төслийн талбайд нэг цэг сонгох	2026 он 9 сар	Шинжилгээний зардал 1 удаагийнх 50.0 * өдөрт 1 удаа * 2 цэг = 100.0 төгрөг зарцуулна. Багажийн түрээсийн зардал: 1 багаж 100.0*1 удаа = 100.0	- MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколори метрийн арга, - MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, - MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, Нүүрс устөрөгчид	Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас Цэвэрлэх байгууламж: бохир усны дээж	2026 он 9 сар	49.0 х жилд 1 удаа х 1 дээж = 49.0 75.0 х жилд 1 удаа х 1 дээж = 75.0	- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага - MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж - MNS 13.060.50 Усны чанарын стандарт - MNS 0900: 2010 Ундны ус. Эрүүл ахуйн - шаардлага, түүнд тавих хяналт
3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ ,	Төслийн талбайд 1 цэг сонгох.	2026 он 9 сар	Нийт 3 цэгт * /20.0 + 25.0/ = 70.0 /Хөрсний химийн шинжилгээ 1дээж-	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга

“Дойдо” ХХК-ний “Бүрэн” аялал жуулчлалын баазын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	К ₂ О), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр			20.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж – 25.0₮/	- MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
	Байгаль орчны хяналт шинжилгээний тухайн жилийн зардлын дүн			394.000	-

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД 7 524.0 МЯН.ТӨГРӨГИЙГ УРЬДЧИЛСАН БАЙДЛААР ТӨЛӨВЛӨЖ ӨГЛӨӨ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Бүрэн” аялал жуулчлалын бааз

Төсөл хэрэгжүүлэгч: “Дойдо” ХХК

Боловсруулсан: “Тэкол” ХХК

Хэрэгжих хугацаа: 2025 – 2029 он.

Өмнөговь аймгийн Сэврэй сум, Сайншанд баг, Говь Гурвансайхан БЦГазар нутагт байрлах “Дойдо” ХХК-ний “Бүрэн” аялал жуулчлалын бааз төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” –ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Тус аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) болон байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.** Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь дараах зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

Агаар, ус, хөрсөн бүрхэвч, ургамал, амьтан болон тухайн орчинд ажиллаж буй хүмүүст төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох, шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжих эхний 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын тооцоог зах зээлийн өнөөгийн үнийн дүнгээр тооцов.

Төсөл хэрэгжүүлэгч БОННУ батлагдсаны дараа жилээс эхлэн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль хамгаалах хууль тогтоомж, төслийн БОННУ-ний үр дүн, батлагдсан БОМТ (энэхүү төлөвлөгөө)-нд үндэслэл болгоно.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн болон хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан зохих шийдвэрийг гаргуулж ажиллах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ - /2025-2029 он/

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгчийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь “Дойдо” ХХК-ний “Бүрэн” аялал жуулчлалын бааз төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно.

Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 1-ний дотор БОАЖЯнд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Гол ба Болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг	Нийт зардал (5-жилээр) /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР						
Аялал жуулчны бааз ашиглалтын явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд төслийн талбай орчмын шороон замаас тоосжилт үүсэх дуу чимээ, уурын зуухны утаа, хог хаягдал зэрэг болно.	Аялал жуулчлалын баазын шинэчлэл, өргөтгөл, цэвэр бохир усны системийн засварын ажлын үед тоосжилт ихсэх үед чийгшүүлэх арга хэмжээг цаг агаарын улирлын байдлыг харгалзан авах	Тоосжилт их гарах нөхцөл байдлын үед	Нэг жилд- 300.0	1.500.0	2025-2029 он	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Монгол Улсын агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005; - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, - Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ - MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
	Баазын үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх	Төслөөс гарч буй хатуу, шингэн бүх төрлийн хог хаягдал. Сард нэг удаа тогтмол хэрэгжүүлэх	-	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	2025-2029 он	
	Аялал жуулчлал, амралтын баазын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утааны бохирдуулагч зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зориулалтын шүүлтүүр тавих, солих	Баазд ашиглагдах тээврийн хэрэгсэл	100.0	500.0	2025-2029 он	
Нийт дүн				1.600.0		

ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС						
Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсцын горим алдагдах, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох. Мөн Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэх зэргээс гүний усыг бохирдуулж болзошгүй.	Бохир ус дамжуулах хоолойн холбооснуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийх	Бохир ус дамжуулах хоолой, холбоос	100.0	500.0	2025-2029 он	- Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. - MNS458698 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.), Усан орчны чанарын хяналт - шинжилгээ - MNS404788 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны чанар, хаягдал бохир ус. - MNS 4943-2014 Байгаль орчныг тухай хамгаалах хууль, Усны хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын –Ус хувь хавсралт ашигласны төлбөрийн хэмжээ
	Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг үерийн болон гадаргын усны урсцаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Төслийн талбай	200.0	1.000.0	2025-2029 он	
	Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж. эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Төсөлд ашиглагдах ус	100.0	500.0	2025-2029 он	
	Ус ашиглалтын гэрээний дагуу төлбөр тооцоог тогтмол цаг тухайд төлж барагдуулж байх	Гүний худаг	-	-	2025-2029 он	
Нийт дүн				2.000.0		

”Дойдо” ХХКомпанийн Өмнөговь аймгийн Сэврэй сумын Сайншанд баг, Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газарт байрлах, “Бүрэн” аялал жуулчлалын баазын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нэмэлт тодотголын тайлан

ХӨРС БОЛОН УРГАМЛАН БҮРХЭВЧ						
